



МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 15 дугаар зүйлийн 15.14.7, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.6-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 208 дугаар тушаалаар томилогдсон Ажлын хэсгийн 2023 оны 02 дугаар сарын 9-ний өдрийн 2023/02 дугаар хурлаас гарсан шийдвэрийн дагуу энэ тушаалын нэгдүгээр хавсралтад заасан 4 /дөрөв/ хуулийн этгээдэд геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилээр олгосугай.

2. Энэ тушаалын хоёрдугаар хавсралтад заасан 5 /тав/ хуулийн этгээдийн геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгасугай.

3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагааг үндэслэн Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 167 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж"-ийн жагсаалтын 3-т заасан "Дорнын үүрийн гэгээ" ХХК-ийн нэрийг "Гео тана сүрвэй" ХХК гэж өөрчилсүгэй.


4. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, сунгасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар /даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Батсайхан/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Баярбат/-т тус тус даалгасугай.



Ц.ДАВААСҮРЭН

152310127

Барилга, хот байгуулалтын сайдын 2023
оны 03 дугаар сарын 08 өдрийн 44 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН ХУУЛИЙН ЭТГЭЭД

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Аж ахуйн нэгжийн регистр	Сунгагдсан тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлийн дугаар /ТЗ 2022/.../	Гэрчилгээний дугаар
1.	"Глобал" лэнд ворк ХХК	6415091	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/001	2023/02/09/001
2.	"Хас баян ундармал" ХХК	6555012	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/002	2023/02/09/002
3.	"Геометр сүрвэй" ХХК	6524478	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/003	2023/02/09/003
4.	"Гео координат" ХХК	6945562	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/004	2023/02/09/004

-----oOo-----

Барилга, хот байгуулалтын сайдын 2023
оны 02 дугаар сарын 06 өдрийн 41... дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ СУНГАСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Аж ахуйн нэгжийн регистр	Олгогдсон тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлийн дугаар /ТЗ 2022/.../	Гэрчилгээний дугаар
1.	"Геодата" ХХК	5698146	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/005	2023/02/09/005
2.	"Эрин кадастр" ХХК	6132855	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/006	2023/02/09/006
3.	"Баясахсүрвэй" ХХК	5336384	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/007	2023/02/09/007
4.	"Бэст сүрвэй" инженеринг ХХК	6443249	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/008	2023/02/09/008
5.	"Онгихайрхан" ХХК	5100593	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ТЗ/2023/009	2023/02/09/009

-----oOo-----